



Батлаа,

“ЭДЦС” ТӨХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Л. ЭРХБААТАР



“ЭРДЭНЭТИЙН ДУЛААНЫ ЦАХИЛГААН СТАНЦ” ТӨХК

“МАЗУТЫН АЖ АХУЙН ХЭМЖҮҮР, АВТОМАТИК, АЛСЫН УДИРДЛАГЫН  
ИЖ БҮРЭН ШИНЭЧЛЭХ” АЖЛЫГ  
ГҮЙЦЭТГЭХ УНИЙН САНАЛ  
АВАХ БАРИМТ БИЧИГ

Орхон аймаг

2020 он

## **Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА**

“Эрдэнэтийн Дулааны Цахилгаан Станц” ТӨХК нь сонирхсон эрх бүхий оролцогчдоос “Мазутын аж ахуйн хэмжүүр, автоматик, алсын удирдлагын иж бүрэн шинэчлэл” ажлыг хийж гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул ([www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 20,000 /хорин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Үнийн саналыг 2020 оны **04-р сарын 21-ны өдрийн 10.00 цагаас** өмнө “ЦАХИМ”-аар буюу [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй оролцогчдыг байлцуулан **2020 оны 04-р сарын 21-ны өдрийн 10<sup>10</sup> цагт** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцохгүй.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Орхон аймаг, Баян өндөр сум, Баянцагаан баг  
“ЭДЦС” ТӨХК-ийн 4 давхар, 423 тоот өрөө,  
НБД М.Ууганбаяр, Утас 9906-7312**

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
  - 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**
  - 4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.
  - 4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.
  - 4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.
  - 4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдэж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**
  - 5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**хүчинтэй  
байх хугацаа**

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
  - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
  - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхийг байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГОХЗААЛТ	Шалгуур үзүүлэлт									
ТОӨЗ 1.1	<p>1. <b>Санхүүгийн тайлан:</b> 2019 оны санхүүгийн тайланг цахим системээс харах тул ирүүлэх шаардлагагүй бөгөөд харин аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайланг материалд хавсаргаж ирүүлэх шаардлагатай.</p> <p>2. <b>Борлуулалтын орлого:</b> 2019 он /санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх/</p> <p>3. <b>Татварын тодорхойлолт:</b> Тендер нээсэн өдрөөр өр төлбөргүй байх</p> <p>4. <b>Нийгмийн даатгалын тодорхойлолт:</b> ТҮЦ машинаас авсан байх</p> <p>5. <b>Гэрчилгээ:</b> Улсын бүртгэл, НӨАТийн гэрчилгээний хуулбар тус бүрийг ирүүлэх</p> <p>6. <b>Эрх бүхий байгууллагын тодорхойлолт:</b> Шүүх, ШШГЕГ, харилцагч банк /өр төлбөргүй тухай/-ны тодорхойлолтууд тендер зарлагдсан өдрөөс хойш авсан байх</p> <p>7. <b>Албан баталгаа:</b> Батлагаат хугацаа 1-ээс дээш жил байх ба албан бичгээр баталгаажуулж ирүүлэх</p> <p>8. <b>Гүйцэтгэлийн баталгаа:</b> Тендерт шалгарсан тохиолдолд санал болгосон үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэхүйц “Гүйцэтгэлийн баталгаа” байршуулж гэрээний хэлцэл хийх эрх үүсэх ба үүнийг зөвшөөрсөн албан бичиг тендерт хавсаргаж ирүүлэх</p> <p>9. <b>Ижил төстэй ажлын мэдээлэл:</b> 2018, 2019 онд хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын гэрээний хуулбарыг ирүүлэх <b>Ижил төстэй ажил гэдэгт нарийн хэмжүүр автоматикин тоног төхөөрөмж сууринуулж байсан ажлыг хамааруулан үнэлгээнд тооцно/</b></p> <p>10. <b>Тусгай зөвшөөрөл:</b> Шаардлагагүй</p> <p>11. <b>Үйлдвэрлэгчийн итгэмжлэл:</b> Ажилд шаардлагатай барааны гарал үүсэл, холбогдох сертификатыг ирүүлэх</p> <p>12. <b>Тоног төхөөрөмж:</b> Ажилд шаардлагатай тоног төхөөрөмжийн жагсаалт, фото зургыг ирүүлэх.</p> <p>13. <b>Ажиллах хүч:</b> Доор дурдсан ажиллах хүч нь компанийн үндсэн ажилтан байх ба 6-аас дээш сар НДШ төлсөн байх</p> <table border="1" style="margin-left: auto; margin-right: auto;"> <tr> <td style="text-align: center;"><b>Мэргэжил</b></td> <td style="text-align: center;"><b>Хүний тоо</b></td> <td style="text-align: center;"><b>Мэргэжлийн</b></td> </tr> <tr> <td style="text-align: center;"><b>Нарийн хэмжүүрийн инженер</b></td> <td style="text-align: center;"><b>1</b></td> <td style="text-align: center;"><b>Диплом</b></td> </tr> <tr> <td style="text-align: center;"><b>Программын инженер</b></td> <td style="text-align: center;"><b>1</b></td> <td style="text-align: center;"><b>Диплом</b></td> </tr> </table>	<b>Мэргэжил</b>	<b>Хүний тоо</b>	<b>Мэргэжлийн</b>	<b>Нарийн хэмжүүрийн инженер</b>	<b>1</b>	<b>Диплом</b>	<b>Программын инженер</b>	<b>1</b>	<b>Диплом</b>
<b>Мэргэжил</b>	<b>Хүний тоо</b>	<b>Мэргэжлийн</b>								
<b>Нарийн хэмжүүрийн инженер</b>	<b>1</b>	<b>Диплом</b>								
<b>Программын инженер</b>	<b>1</b>	<b>Диплом</b>								
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:          Байгууллагын хаяг: “ЭДЦС” ТӨХК          Цахим хаяг: <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> цахим хаягаар хүлээн авна.  <b>Огноо:</b> 2020 оны 04 дугаар сарын 21-ны өдөр          Цаг: 10 цаг 00 минут</p>									
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:          Байгууллагын хаяг: “ЭДЦС” ТӨХК,          Давхар болон өрөөний дугаар: 4-н давхар, 423 тоот өрөө  <b>Огноо:</b> 2020 оны 04 дугаар сарын 21-ны өдөр          Цаг: 10 цаг 10 минут</p>									

<b>ТОӨЗ 2.3</b>	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягтуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li><b>1. Үнийн санал:</b> Маягтын дагуу</li> <li><b>2. Ажил гүйцэтгэх хуваарь:</b> Маягтын дагуу</li> <li><b>3. Шүүхийн тодорхойлолт:</b> Эх хувь</li> <li><b>4. Мэдэгдэл:</b> ТБОНӨХБАҮХАТХ-ийн 14.1 дэх хэсэг үүсээгүйг албан бичгээр мэдэгдэх</li> </ol> <p><i>Дээрх бичиг баримтуудыг тендерт оролцогч нарт нээлтэй үзүүлэхийг зөвшөөрсөн мэдэгдэл ирүүлэх.</i></p>
<b>ТОӨЗ 6.2</b>	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>[Нэг]</b></p> <p><i>ТОӨЗ-ны 1.1 болон 2.3-т шаардсан материалындаас аль нэгийг ирүүлээгүй нь үнийн саналаас татгалзах үндэслэл болно.</i></p>

## Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Мазут аж ахуйн хэмжүүрүүдийг шинэчлэхэд  
хийгдэх ажлын нөхцөл

Тухайн ажил нь мазут аж ахуйд байрласан зарцуулалтын 1ш, даралтын 1ш, температурын 13ш, түвшиний Зш хэмжүүрийг солих, суурилуулах, түүнтэй комплект болох анхдагч, хоёрдогч хаалтууд, температурын гилькүүд, кабель монтаж бүгдийг шинээр татах, хаяг бирюжүүлэлт хийх, зүгшрүүлэлт тохируулгын ажлууд хийгдэнэ.

Тухайн цэгүүд нь мазут аж ахуйн шитэнд байрлаж монтаж угсралтууд нь хийгдэж компьютер дээр заахаас гадна, шилэн кабель татаж дулааны ерөнхий шит №1,2-т програмчлагдсан удирдлагаар харах нөхцөлийг хангана.

Хуучин кабелиуд болон хэмжүүр датчикуудын демонтажыг хийнэ. Шинээр татах удирдлагын болон мэдээллийн кабелиуд нь зэс голтой ачаалалт даах чадвартай, резерв 2-3 үзүүртэй, чанарын шаардлага хангасан байна.

Хэмжүүр, датчик, монтаж угсралтын ажлууд нь техник ашиглалтын дүрмийн дагуу холбогдох хүмүүсийн хяналтан дор хийж гүйцэтгэгдэнэ.

Шитэнд байрлах компьютер нь тасралтгүй горимд ажиллах ачаалал даах чадвартай Dell фирмтэй дүйцэхүйц, CPU нь i5 ба, RAM нь 4 GB-с дээш үзүүлэлттэй байх. UPS (Uninterruptible Power Supplies) тавих шаардлагатай. Энэ нь давтамж болон далайцын ихсэх, багасах хамгаалалттай байна. UPS нь тэжээл тасарснаас хойш хамгийн багадаа 30 минут системийг тэжээлээр хангах чадалтай байхаар тооцох. Мөн контроллёр, модулийн тэжээлийн блок нь яг тухайн контроллёр, модулийн дагалдах тэжээлийн блок модуль байна. Тус компани нь шинээр тавигдах монтаж угсралтын бүх талын ажлыг бүрэн гүйцэд хийнэ.

Программын лицензийг зөөвөрлөх боломжтой буюу dongle key – тэй байх. Удирдлагын программ нь үйлдвэрийн процессийг удирдахад хялбар болгож, хүнд ойлгомжтой харгдах байдлаар хийнэ. График, ажилласан цаг, хоногийн үзүүлэлтүүдийг шаардлагатай хэлбэрээр гаргах программтайгаар хийгдэнэ. Принтертэй байна

Газардуулгын системийг техник ашиглалтын дүрмийн дагуу хийж холбосон байна. Станцын ерөнхий газардуулгаас тусад нь хийсэн байна.

Түвшин дээр тавигдах Зш датчик нь өвлийн цагт битүү уран дотор, 90<sup>0</sup>C температурт ажиллах чадвартай, ус чийгний IP67 стандартыг хангасан, 4-20mA-ийн гаралттай, өөр дээрээ давхар заадаг датчик байх шаардлагатай.

Тухайн шалгарсан компанид гэрээний хэлцэл хийх үед шаардлагатай техникийн орчин нөхцөл, хэмжих хязгаар, датчикны уртыг зааж өгнө.

Тухайн ажлыг хийж гүйцэтгэх компаний анхаарах зүйлс:

1. Аюулгүй ажиллагаа, техник ашиглалтын дүрэмд нийцсэн монтаж угсралтыг хийх
2. Кабель монтажыг стандарт, дүрмийн дагуу хийхээс гадна хаяг бирюжүүлэлтийг, цэвэр үзэмжтэй хийсэн байна.
3. Кабелийн трассын бүрэн бүтэн байдал, нягтруулга чигжээсүүдийг хийх
4. Цехийн ажилчдад монтаж угсралт, схем зургийн талаар сургалт зохион байгуулна.
5. Тавигдсан тоног төхөөрөмжийн ашиглалтын заавар, холболт схем, тэжээлийн схем, монтаж угсралтын схем зураг бусад холбогдох бичиг баримтыг Англи болон Монгол хэл дээр 3 хувь хүлээлгэн өгнө.

Тухайн ажилд орох материал:

Д/Д	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо Ширхэг
1	Зарцуулалтын датчик smart 4-20 мА гаралттай	ш	1
2	Даралтын датчик smart 4-20 мА гаралттай 0-10 кгс/см2	ш	1
3	Температурны датчик Pt-100 0-150 °C	ш	13
4	Тувшиний датчик smart 4-20 мА гаралттай	ш	3
5	Гильз штуцер	КОМ	13
6	Мэдээллийн кабель КВВГ 4x1,5	м	50
7	Мэдээллийн кабель КВВГ 3x1,5	м	300
8	ДУ10 РУ 100	ш	6
9	Затворный винтель ДУ15 РУ160 М 20x1,5	ш	10
10	Холболтын хайрцаг 200x90x40	ш	1
11	APAX-5520	ш	1
12	APAX-5002	ш	3
13	APAX-5013	ш	2
14	APAX-5017	ш	1
15	Тэжээлийн блок 24В	ш	1
16	Шилэн кабель	м	600
17	Стайшн компьютер	КОМ	1
18	KW Multiprog 5.35	ш	1
19	Indusoft Web Studio 7.1	ш	1
20	Хоногийн үзүүлэлтийн програм хангамж	ш	1
21	Media converter	ш	2
22	UPS тэжээл баригч 220В	ш	1
23	Принтер	ш	1

### Тав. ЗУРАГ

#### Зургийн санамж

Энд зургуудыг жагсааж бичнэ. Зураг, түүний дотор ажлын талбайн зургийг энэ бүлэгт, эсхүл тусад нь хавтсанд хийж хавсаргана.

### Зургаа. ҮЕ ШАТНЫ АЖЛЫН ХУВААРЬ

#### Үе шатны ажлын хуваарь бэлтгэх санамж

##### Зорилт

Үе шатны ажлын хуваарийг дараах зорилгоор бэлтгэдэг. Үүнд:

- гэрээний дагуу гүйцэтгэх ажлын тоо хэмжээний талаар хангалттай мэдээллийг гаргаж тендерийг зохих ёсоор, нягт нямбай бэлтгэх бололцоог олгох;
- гэрээ байгуулсны дараа ажлын гүйцэтгэлийг тооцож үнэлэхэд үе шатны ажлын хуваарьт заасан үнийг үндэслэх.

Эдгээр зорилтыг хэрэгжүүлэхийн тулд үе шатны ажлын хуваарьт хоорондоо ялгаатай ажлуудын, эсхүл өөр өөр газар гүйцэтгэх ижил төстэй ажлын ялгааг гаргаж өгөх, эсхүл өргтийг ялгаатайгаар авч үзэх нөхцөлийг харгалзах зорилгоор үе шатны ажлын хуваарийг зохих нэр төрлөөр нь задлах хэрэгтэй. Эдгээр шаардлагатай нийцүүлэн үе шатны ажлын хуваарийн

агуулга аль болохоор энгийн бөгөөд товч байх ёстой. Гадна тохижилтын ажил болон нөхөн сэргээх зардлыг үе шатны ажлын хуваарьт заавал оруулна.

### **Ажил-өдрийн хуваарь**

Ажил-өдрийн хуваарийг үе шатны ажлын хуваарийн нэр төрөлд тусгагдаагүй магадлашгүй ажил гарах магадлал өндөр бол оруулна. Тендерт оролцогчийн ирүүлсэн нэгж үнэ бодитой эсэхийг шалгах боломжийг захиалагчид олгох зорилгоор ажил-өдрийн хуваарь нь ихэвчлэн дараах зүйлээс бүрдэнэ:

(а) тендерт оролцогч ажил-өдрийн нийт үнийг бөглөж ирүүлэх ажиллах хүч, материал, барилга байгууламжийн нэр төрлийн жагсаалт. Мөн ажил-өдрийн хэлбэрээр гүйцэтгэсэн ажилд төлбөр хийх нөхцөлийн талаарх мэдээлэл.

(б) тендерт оролцогч бүрийн нэгж үнээр үнэлж ирүүлэх ажил-өдрийн нэр төрлийн тоо хэмжээ. Тендерт оролцогчийн ажил-өдрийн нэр төрөлд санал болгох нэгж үнэ нь гүйцэтгэгчийн ашиг, захиргааны, хяналтын болон бусад зардлыг багтаасан байна.

### **Магадлашгүй зардал**

Магадлашгүй ажлын зардалд зориулсан тодорхой мөнгөн дүнг үе шатны ажлын хуваарьт заах замаар магадлашгүй ажлын зардлын талаар ерөнхий заалт оруулж болно. Мөн үнийн өсөлтөд зориулсан тодорхой дүнг магадлашгүй зардал хэлбэрээр үе шатны ажлын хуваарьт зааж болно. Магадлашгүй зардлыг гэрээнд тусгах нь ирээдүйд шаардлага гарсан үед нэмэлт төсөв хуваарилуулж батлуулах ажиллагаанаас зайлсхийх бололцоо олгоно. Магадлашгүй зардлыг хэрэглэсэн үед гэрээний тусгай нөхцөлд тэдгээрийг хэний зөвшөөрлөөр (ихэвчлэн төслийн менежерийн) хэрхэн хэрэглэх аргыг заана.

*Үе шатны ажлын хуваарь бэлтгэхэд зориулсан энэ санамж нь зөвхөн захиалагч болон тендериин баримт бичгийг боловсруулж буй хүмүүст зориулагдсан болно. Эдгээрийг эцсийн баримт бичигт оруулахгүй.*

## **Долоо. ЖИШИГ МЯЯГТ**

### **ҮНИЙН САНАЛЫН МЯЯГТ**

[огноо]

**(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа**

- Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендериин үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендериийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
- Тендер нь тендериийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
- Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
- Бид тендериийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендериийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |   |
|---|---|
| <p><b>1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх</b></p> <p><b>2. Төслийн менежерийн шийдвэр</b></p> <p><b>3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх</b></p> <p><b>4. Аюулгүй байдал</b></p> <p><b>5. Зааварчилгаа</b></p> <p><b>6. Маргааныг шийдвэрлэх</b></p> | <p>1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>2.1. Гэрээнд тусгайллан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ.</p> <p>3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана.</p> <p>4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.</p> <p>4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ.</p> <p>5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй</p> <p>6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.</p> |
| <b>Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ</b>  |   |
| <p><b>7. Ажлын хөтөлбөр</b></p> <p><b>8. Зөрчил, гологдол илрүүлэх</b></p> <p><b>9. Зөрчил, гологдол арилгах</b></p>  | <p>7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.</p> <p>7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана.</p> <p>8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй.</p> <p>9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа<sup>1</sup> дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.</p> |

<sup>1</sup> Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- |   |   |
|---|---|
| <b>10. Зөрчил, гологдол арилгахгүй байх</b> | <p>9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардаар арилгана.</p> <p>10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.</p> |
|---|---|

## **В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ**

- |   |  |
|---|--|
| <b>11. Үе шатны ажлын хуваарь</b>           | <p>11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарь тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.</p> <p>11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.</p> |
| <b>12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх</b> | <p>12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарь нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.</p>  |
| <b>13. Алданги</b>                          | <p>13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги<sup>2</sup> төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс сүүтган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.</p>                                 |

## **Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ**

- |                          |  |
|--------------------------|--|
| <b>14. Ажил дуусгах</b>  | <p>14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлцуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.</p>   |
| <b>15. Хүлээж авах</b>   | <p>15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.</p>  |
| <b>16. Эцсийн тооцоо</b> | <p>16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хургуулнэ.</p> <p>Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно.</p> <p>Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хургуулнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.</p> |

---

<sup>2</sup> Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

<b>17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага</b>	<p>17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.</p> <p>17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүй улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дунг суутгана.</p>
<b>18. Гэрээг цуцлах</b>	<p>18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.</p> <p>18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:</p> <ul style="list-style-type: none"> <li>(а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;</li> <li>(б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;</li> <li>(в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буудсан;</li> <li>(г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;</li> <li>(д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.</li> </ul> <p>18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.</p>
<b>19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр</b>	<p>19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.</p> <p>19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.</p>

**20. Гүйцэтгэлээс чөлөөлөх** 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсоно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

### Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ<sup>3</sup>

<b>ГЕН 2.1</b>	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: ““Мазутын аж ахуйн хэмжүүр, автоматик, алсын удирдлагын иж бүрэн шинэчлэл”
<b>ГЕН 2.1</b>	Ажил нь [төвч тодорхойлолт, түүний дотор төслийн хүрээнд бусад гэрээтэй холбогдох байдал]-аас бүрдэнэ.  Ажлын талбай нь “ЭДЦС” ТӨХК-д байрших ба зураг №...-д зааснаар тодорхойлогдсон болно.
<b>ГЕН 3.1</b>	Төслийн менежер нь Гэрээ байгуулах үед томилогдно.
<b>ГЕН 4.1</b>	Ажил эхлэх өдөр: Гэрээ байгуулсан өдөр  Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: 2020.05.01
<b>ГЕН 7.1</b>	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш [тоо] хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
<b>ГЕН 9.1</b>	Чанарын баталгаат хугацаа 1 жил болон түүнээс дээш байна.
<b>ГЕН 13.1</b>	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,1 хувь байна.  Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10 хувь байна.
<b>ГЕН 17.1</b>	Ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээ дүгнэхээс өмнө гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг ажил хүлээлцэх өдрөөөс өмнө гаргаж өгнө.  Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд сутгах төлбөрийн хэмжээ гэрээний үнийн 5 хувь байна.
<b>ГЕН 19.1</b>	Ажил дуусгахад захиалагчаас гарах нэмэлт зардлыг дуусаагүй ажлын 0 хувиар тооцно.

<sup>3</sup> Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

## ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
(Албан тушаал)	(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ сарын \_\_\_\_\_-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: \_\_\_\_\_ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг; 20.... онд: \_\_\_\_\_ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь \_\_\_\_\_ байршилтай \_\_\_\_\_ хүчин чадал бүхий \_\_\_\_\_ ам.метр талбай / \_\_\_\_\_ шоо метр эзлэхүүн/-тай, \_\_\_\_\_ суурь, \_\_\_\_\_ хана, \_\_\_\_\_ хучилттай, \_\_\_\_\_ давхар \_\_\_\_\_ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж сууринуулах/-ын ажлыг \_\_\_\_\_ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, \_\_\_\_\_ туслах барилга /бусад ажил/-ын хамт \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр эхэлж, \_\_\_\_\_ оны \_\_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_\_-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь :
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

#### **ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

#### **ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]